

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/58/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Сааранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/147
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон бусад эх үүсвэрээр төрийн албан хаагчдын 4-н айлын орон сууц 199,950.0 мянган төгрөг, 2 дугаар багийн байр 120,000.0 мянган төгрөгөөр шинээр баригдаж, 7,500.0 мянган төгрөгийн мотоцикл тус тус орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,082,758.00	133,984,190.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	333,000.00	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	333,000.00	0
31210	Төгрөг	333,000.00	0
31213	Арилжааны банк дахь харилцах	333,000.00	0
33	АВЛАГА	1,900,000.00	0
33500	Бусад авлага	1,900,000.00	0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,900,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	134,849,758.00	133,984,190.00
35100	Түүхий эд материал	180,000.00	180,000.00
35130	Эм боох материал	180,000.00	180,000.00
35400	Хангамжийн материал	102,264,758.00	101,399,190.00
35410	Бичиг хэргийн материал	4,745,335.00	5,005,195.00
35420	Аж ахуйн материал	73,125,596.00	77,077,946.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,593,499.00	7,948,499.00
35470	Бусад хангамжийн материал	17,800,328.00	11,367,550.00
35600	Мал амьтад	32,405,000.00	32,405,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,176,492,754.24	1,477,383,897.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,176,492,754.24	1,477,383,897.09
39200	Биет хөрөнгө	1,173,408,754.24	1,474,299,897.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	628,407,092.23	978,357,092.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,342,226.45	-59,990,449.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	190,920,921.00	198,420,921.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-129,537,370.25	-143,750,977.10
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	82,977,410.00	94,399,460.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,647,056.61	-31,355,936.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,390,225.00	46,360,225.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,943,490.24	-21,654,542.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	780,710,964.00	785,348,064.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-329,527,714.44	-371,833,959.98
39300	Биет бус хөрөнгө	3,084,000.00	3,084,000.00
39301	Програм хангамж	2,035,000.00	2,035,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,285,000.00	-1,285,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,334,000.00	2,334,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,313,575,512.24	1,611,368,087.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	383,000.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	383,000.00	0
41300	Өглөг	383,000.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	50,000.00	0
41360	Бусад өглөг	333,000.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	333,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,313,192,512.24	1,611,368,087.09
51	Засгийн газрын хувь оролцоо	1,313,192,512.24	1,611,368,087.09
51100	Засгийн газрын оруулсан капитал	477,550,842.95	0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	477,550,842.95	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	477,550,842.95
51200	Хуримтлагдсан үр дүн	533,114,023.55	831,289,598.40
51210	Өмнөх үеийн үр дүн	527,730,851.90	533,114,023.55
51220	Тайлант үеийн үр дүн	5,383,171.65	298,175,574.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,527,645.74	302,527,645.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,313,575,512.24	1,611,368,087.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,182,000.00	270,486,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	51,182,000.00	270,486,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	270,486,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	270,486,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	46,284,000.00	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,898,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	547,464,510.70	617,987,311.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,342,710.70	186,919,611.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	17,625,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	10,750,053.00	134,718,094.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	108,967,657.70	52,201,517.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	410,121,800.00	431,067,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	410,121,800.00	431,067,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	589,136,289.05	590,298,536.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	589,136,289.05	586,005,086.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,856,137.88	525,091,249.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,740,668.90	222,974,922.23
210101	Үндсэн цалин	197,903,258.19	166,893,586.31
210102	Нэмэгдэл	16,833,208.71	30,733,632.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	7,590,296.77
210104	Урамшуулал	0	10,377,985.01
210105	Гэрээт ажлын хөлс	25,004,202.00	7,379,421.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,189,557.00	27,449,405.59
210201	Тэтгэврийн даатгал	22,160,553.39	18,710,900.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,280,138.53	2,207,952.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,822,510.70	1,766,122.22
210204	Ажилгүйдлийн даатгал	447,750.47	426,939.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,478,603.91	4,337,490.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,359,631.00	35,091,109.00
210301	Гэрэл, цахилгаан	3,175,036.00	2,906,510.00
210302	Түлш, халаалт	32,184,595.00	32,184,599.00
2104	Хангамж, бараа материалын зардал	109,382,465.00	56,671,048.00
210401	Бичиг хэрэг	1,767,700.00	1,955,500.00
210402	Тээвэр, шатахуун	23,190,220.00	24,990,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,739,300.00	1,200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	271,100.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	82,414,145.00	28,525,478.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	361,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,855,000.00	9,209,258.00
210604	Урсгал засвар	1,855,000.00	9,209,258.00
2107	Томилолт, зочны зардал	5,472,000.00	4,306,100.00
210702	Дотоод албан томилолт	5,472,000.00	4,306,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,954,788.00	29,430,082.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	1,162,518.00	28,243,637.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	403,920.00	523,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	242,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,902,027.98	139,598,324.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,379,477.63	55,010,317.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,600.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,458,950.35	84,588,007.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,280,151.17	60,913,836.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,798,600.00	26,332,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	23,832,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,798,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	53,481,551.17	34,581,636.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,481,551.17	34,581,636.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	4,293,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	4,293,450.00
221001	Их засвар	0	4,293,450.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,510,221.65	298,175,574.85
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,127,050.00	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	4,127,050.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,383,171.65	298,175,574.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	547,464,510.70	618,087,311.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	547,464,510.70	617,987,311.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,342,710.70	186,919,611.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,625,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны	10,750,053.00	134,718,094.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	108,967,657.70	52,201,517.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	410,121,800.00	431,067,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410,121,800.00	431,067,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	537,140,800.70	489,056,311.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	537,140,800.70	489,056,311.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,860,649.53	428,142,474.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,749,968.90	222,974,922.23
210101	Үндсэн цалин	199,811,057.19	166,893,586.31
210102	Нэмэгдэл	16,833,208.71	30,733,632.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	7,590,296.77
210104	Урамшуулал	0	10,377,985.01
210105	Гэрээт ажлын хөлс	23,105,703.00	7,379,421.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,189,557.00	27,449,405.59
210201	Тэтгэврийн даатгал	22,160,553.39	18,710,900.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,280,138.53	2,207,952.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,822,510.70	1,766,122.22
210204	Ажилгүйдлийн даатгал	447,750.47	426,939.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,478,603.91	4,337,490.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,359,631.00	35,091,109.00
210301	Гэрэл, цахилгаан	3,175,036.00	2,906,510.00
210302	Түлш, халаалт	32,184,595.00	32,184,599.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,967,220.00	25,154,440.00
210401	Бичиг хэрэг	3,666,000.00	1,276,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,131,480.00	21,994,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,044,290.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	125,450.00	683,590.00
2105	Нормативт зардал	0	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	10,998,438.00
2107	Томилолт, зочны зардал	5,522,000.00	4,356,100.00
210702	Дотоод албан томилолт	5,522,000.00	4,356,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,458,023.00	32,528,461.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,665,753.00	31,474,016.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	403,920.00	523,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,114,249.63	69,089,598.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,958,249.63	69,089,598.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,280,151.17	60,913,836.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,798,600.00	26,332,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	23,832,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,798,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	53,481,551.17	34,581,636.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,481,551.17	34,581,636.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,323,710.00	129,031,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,990,710.00	129,364,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,990,710.00	129,364,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,990,710.00	129,364,000.00
223001	Бусад хөрөнгө	2,281,310.00	29,364,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,709,400.00	100,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-9,990,710.00	-129,364,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	333,000.00	-333,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	333,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333,000.00	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,842.95	302,527,645.74	527,730,851.90	1,307,809,340.59
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	477,550,842.95	302,527,645.74	527,730,851.90	1,307,809,340.59
9	Тайлант үеийн үр дүн	0	0	5,383,171.65	5,383,171.65
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,842.95	302,527,645.74	533,114,023.55	1,313,192,512.24
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	477,550,842.95	302,527,645.74	533,114,023.55	1,313,192,512.24
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	477,550,842.95	302,527,645.74	533,114,023.55	1,313,192,512.24
19	Тайлант үеийн үр дүн	0	0	298,175,574.85	298,175,574.85
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	477,550,842.95	302,527,645.74	831,289,598.40	1,611,368,087.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	431,694,800.00	417,943,554.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,330,800.00	388,579,554.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,830,800.00	386,079,554.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,670,900.00	222,974,922.23
210101	Үндсэн цалин	179,374,300.00	166,893,586.31
210102	Нэмэгдэл	26,208,600.00	30,733,632.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,088,000.00	7,590,296.77
210104	Урамшуулал	8,000,000.00	10,377,985.01
210105	Гэрээт ажлын хөлс	0	7,379,421.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,330,600.00	27,449,405.59
210201	Тэтгэврийн даатгал	21,343,700.00	18,710,900.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,246,700.00	2,207,952.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,797,400.00	1,766,122.22
210204	Ажилгүйдлийн даатгал	449,400.00	426,939.80
210205	Эрүүл мэндийн даатгал	4,493,400.00	4,337,490.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,255,500.00	35,091,109.00
210301	Гэрэл, цахилгаан	4,045,500.00	2,906,510.00
210302	Түлш, халаалт	34,110,000.00	32,184,599.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,177,800.00	22,177,800.00
210401	Бичиг хэрэг	1,276,000.00	1,276,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,701,800.00	19,701,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,200,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	10,998,438.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	10,998,438.00
2107	Томилолт, зочны зардал	4,356,100.00	4,356,100.00
210702	Дотоод албан томилолт	4,356,100.00	4,356,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	36,430,900.00	32,528,461.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	34,920,900.00	31,474,016.38
210802	Аудит, баралгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	816,000.00	523,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,109,000.00	30,003,318.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,109,000.00	30,003,318.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.00	2,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,364,000.00	29,364,000.00
223001	Бусад хөрөнгө	29,364,000.00	29,364,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	431,694,800.00	431,167,700.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	402,330,800.00	431,067,700.00
320001	Орон нутгийн төсвөөс	402,330,800.00	431,067,700.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	29,364,000.00	100,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	100,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	29,364,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	333,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,342,710.70	186,919,611.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,342,710.70	86,919,611.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	109,064,623.00	42,062,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	596,950.00	2,976,640.00
210401	Бичиг хэрэг	596,950.00	0
210402	Тээвэр, шатахуун	0	2,293,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	683,590.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,514,053.00	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,514,053.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,953,620.00	39,086,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,953,620.00	39,086,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,278,087.70	44,856,691.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	23,832,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	23,832,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,278,087.70	21,024,491.70
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	28,278,087.70	21,024,491.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	100,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	100,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	100,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	137,342,710.70	186,919,611.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,342,710.70	186,919,611.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,625,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,750,053.00	134,718,094.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	108,967,657.70	52,201,517.70
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын харьяа төрийн байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 19- ний өдрийн А/10 тоот “Дотоод хяналтын баг томилох тухай” тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” -ыг баталсан байна.

Дотоод хяналтаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санхүүгийн үйл ажиллагаанд өөр шалгалт хийгдээгүй дотоод хяналт хангалтгүй ажилласан байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний

гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилэн баталж санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна. Аймгийн ТЭЗ-ийн хэмжээнд мөрдөж ажиллах НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулагдсан бөгөөд хэвлэлтээс гараагүй учир ЗДТГ-ын даргын тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 307,042.6 мянган төгрөгөөр буюу 23,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	333.0	-	(333.0)
Урьдчилгаа	-	-	-
Авлага	1,900.0	-	(1,900.0)
Бараа материал	134,849.8	133,984.2	(865.6)
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	1,176,492.8	1,477,383.9	300,891.1
Нийт хөрөнгө	1,313,575.5	1,611,368.1	297,792.6
Өр төлбөр	383.0	-	(383.0)
Засгийн газрын хувь оролцоо	1,313,192.5	1,611,368.1	298,175.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	1,313,575.5	1,611,368.1	297,792.6

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд 1,900.0 мянган төгрөгийн өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулсан байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 134,849.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 133,984.2 мянган төгрөг буюу 865.5 мянган төгрөгөөр буурсан байна. Аж ахуйн материал болон бусад хангамжийн материал 88,326.6 мянган төгрөг буюу нийт үлдэгдлийн 66,0 хувийг, мал амьтад 32,405.0 мянган төгрөг буюу 24,2 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,176,492.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,477,383.9 мянган төгрөг болж, 300,891.1 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон бусад эх үүсвэрээр төрийн албан хаагчдын 4-н айлын орон

сууц 199,950.0 мянган төгрөг, 2 дугаар багийн байр 120,000.0 мянган төгрөгөөр шинээр баригдаж, 7,500.0 мянган төгрөгийн мотоцикл зэрэг хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,611,368.1 мянган төгрөг болж 298,175.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 414,369.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 2,186.8 мянган төгрөгөөр нэмж 416,555.8 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна. Тус байгууллагын батлагдсан төсөвт Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийн хүрээнд тодотгол хийж 15,139.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 431,694.8 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг төслийг 17,325.8 мянган төгрөгөөр нэмж 431,694.8 мянган төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 431,694.8 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 431,067.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 13,557.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 417,510.6 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь санхүүжилт 627.1 мянган төгрөгөөр эх үүсвэрийг дутуу санхүүжүүлсэн, зарцуулагдаагүй 13,557.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101	273,562.10	265,939.95	7,622.2	97.2
2	70106-80103	42,289.00	38,733.55	3,555.4	91.6
3	70106-80106	61,509.70	60,941.65	568.0	99.1
4	70106-80802	2,500.00	2,500.00	0.0	100.0
5	70106-80918	29,364.00	29,364.00	0.0	100.0
6	70106-81102	10,000.00	10,000.00	0.0	100.0
7	70106-82801	5,000.00	4,961.05	38.9	99.2
8	71411- 81701	5,770.00	3,370.35	2,399.7	58.4
9	71411- 82212	1,700.00	1,700.00	0.0	100.0
	Нийт дүн	431,694.8	417,510.6	14,184.2	93.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 35 арга хэмжээ батлагдаж 88,0 %-тай хэрэгжиж дүгнэгдсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд өвс тэжээлийн үнэ 13,171.4 мянган төгрөг, архивын лавлагаа 147.0 мянган төгрөг, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдын тэтгэмж 23,832.2 мянган төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх шатахууны болон бусад зардал 4,312.2 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын урамшуулал 3,573.7 мянган төгрөг, хандив 10,500.0 мянган төгрөг, тендерийн хураамж 105.0 мянган төгрөг, хянан магадалгааны зардалд 3,000.0 мянган төгрөг, Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт 100,000.0 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 28,278.1 мянган төгрөг, нийт 186,919.6 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас тээвэр шатахуунд 2,293.1 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 683.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 39,086.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 23,832.2 мянган төгрөг, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг 21,024.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлж 186,919.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж хэрэгжилтийг хангах, иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй чанартай хүртээмжтэй хүргэнэ.	98.2	424,224.8	412,440.2
2	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.32	Нийтийн эзэмшлийн хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэгийн үйл ажиллагааг хэвийн явуулна.	79.2	7,470.0	5,070.4
Нийт дүн				88.7	431,694.8	417,510.6

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ 88,7 %-ийн хэрэгжилттэй тайлагнахад нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №03/27 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Баянцагаан сумын ИТХ-ын баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баянцагаан сумын ИТХ-ын баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 431,694.8 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 6,475.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,856.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тооцохдоо өмнөх оны батлагдсан төсөвтэй тайлант оны батлагдсан төсвийг харьцуулан дүн шинжилгээ хийхэд 9,390.0 мянган төгрөгөөр батлагдсан төсөв өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд мэдээлсэн байдлын хэрэгжилт 76,6%-тай, мэдээллийг байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж алдаа зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар харилцагч байгууллагатай хийсэн 115,943.6 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг үнэн зөв байршуулаагүй, өмнөх сарын мэдээг өөрчлөөгүй, хугацаа хоцроож байршуулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 65,733.3 мянган төгрөгийн /өссөн дүнгээр/ мэдээллийг байршуулаагүй, Цалингийн сангаас 759.7 мянган төгрөгөөр интернетийн төлбөр, гар ариутгагч, витамин авч зориулалт бус зардал гаргасан зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Албан шаардлагын хэрэгжилтийг Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 02/157 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	193,545.3	3	193,545.3	80.0
Нийт дүн	3	193,545.3	3	193,545.3	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын зарцуулалтаас шатахуун болон мал, амьтадын тооцоог нарийвчлан шалгах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 178,534.9 мянган төгрөгийн алдаа¹ залруулагдсан болно.

Залруулсан алдаа

1.Илрүүлэлт: Өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн байдлын эцсийн үлдэгдлийг 4-р улирлын эхний үлдэгдэлтэй зэрэгцүүлэн тулгалт хийхэд богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 333.0 мянган төгрөг, хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 1,567.4 мянган төгрөг, өмнөх үеийн үр дүнгийн үлдэгдэл 1,234.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Илрүүлэлт: Бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хандиваар болон шилжүүлэн авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулгахад 136,905.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалтай тулгахад 24,938.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогыг зарлагыг 13.557.4 мянган төгрөгийн татан төвлөрүүлсэн тохируулга хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 23,182.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 311.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 10,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 12,371.2 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн.

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд архивын лавлагаа, цахим тендерийн хураамж зэрэг орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн орлогын дансанд 311.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

1. Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоох

Илрүүлэлт: ЗДТГ-ын нь ААНБ-аас 10,500.0 мянган төгрөгийн хандив авч Төв түмний цэнгэл наадам хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно”, 25.5.1-д “хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд төлбөрийн цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 12,371.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх зааврын 5.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг Татварын е-тах системд орж бүртгэсэн эсэхийг сар бүр тооцоо нийлж зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутгийн орлогын дансанд 311.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлээгүй байна.	1	311.0	1	311.0	-	-	-	-	-	-	-	-
ЗДТГ-ын нь ААНБ-аас 10,500.0 мянган төгрөгийн хандив авч Төв түмний цэнгэл наадам хийсэн байна.	1	10,500.0			1	10,500.00	-	-	-	-	-	-
Төлбөрийн цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 12,371.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	12,371.2			-	-	1	12,371.20	-	-	-	-
Нийт дүн	3	23,182.2	1	311.0	1	10500	1	12,371.2	-	-	-	-

